

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, ялангуяа ажилд орсны дараах дэмжлэг нэн чухал" (2018.11.07)**

9-р сард Япон улсад зохион байгуулагдсан сургалтын тайлангийн хурал зохион байгуулагдлаа. Тус сургалтанд ХБХХЕГ-ын Тамгын газрын дарга Хурцэцэг болон ХБХЭЭХ-ны захирал Сэлэнгэ нар оролцсон юм. Сургалт ойролцоогоор 1 сарын хугацаанд Японы хамгийн урд арал болох Окинавад болсон бөгөөд Ази, Африкийн 10 гаруй орны оролцогчидтой хамт Япон болон бусад орнуудын ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, бие даан амьдрах болон хүртээмжийн талаар суралцаад иржээ. Хоёр оролцогчдын хувьд онцолж авсан сэдэв нь ажилд орсны дараах дэмжлэг байлаа. Японд "Job coach" гэдэг мэргэжилтэй хүн ХБИ-ийг ажил орсны дараа нь ажлын байран дээр нь хамт байн, ажлаа ойлгож суртал нь дэмжлэг үзүүлдэг. Мөн ажил олгогчтой харьцах үед нь ч туслалцаа үзүүлдэг байна. "Ажлаа урт хугацаанд үргэлжлүүлэх боломжийг хангахын тулд тухайн хүн болоод хамт олон нь дасах хүртэлх хугацаанд дэмжлэг туслалцаа шаардлагатай. Монголд ч гэсэн энэ тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай" гэсэн саналыг хуралд оролцогч 80 гаруй хүн идэвхтэйгээр сонсон, санал бодлоо хуваалцлаа.



*Хурцэцэг дарга*



*Сэлэнгэ захирал*

**2 дахь удаагийн цуврал сургалт амжилттай дууслаа (2018.10.30)**

Хөгжлийн бэрхшээлийн талаарх 2 дахь удаагийн цуврал сургалт амжилттай зохион байгуулагдаж дууслаа. Энэ удаагийн цуврал сургалтаар 6 удаагийн хичээл орсон ба өнөөг хүртэл нийт 12 удаагийн хичээлд идэвхтэй оролцсон та бүхэнд гүн талархал илэрхийлье. Сургалтын төгсгөлд нийт 6 удаагийн цуврал хичээлүүдэд 100 хувийн ирцтэйгээр хамрагдсан болон 5 удаа амжилттай оролцсон хүмүүст сертификат гардуулав. Хичээл бүр дээр ойролцоогоор 50 орчим хүн хамрагдаж байсан нь маш талархуштай явдал боллоо. Сертификат гардуулах арга хэмжээнд ХБХХЕГ-ын дэд дарга Ганболд оролцож, нийт оролцогчдод мэндчилгээ дэвшүүлсэн. Дараагийн цуврал сургалтыг 2019 оны 1-р сард эхлүүлэхээр төлөвлөж буй бөгөөд нийт 6 удаагийн хичээл заана. Сургалтыг ямар агуулгаар явуулахаа одоохондоо нарийн шийдээгүй байгаа учраас та бүхэн өөрийн хүсэлтээ бидэнд илгээвэл баяртай байх болно.



*Дэд дарга  
Ганболд*



*Оролцогчдод сертификат гардуулав*



*Сургалтын үеэр*

**JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй!!**

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **3597** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

<https://www.facebook.com/jicadpub/>



## Эрдэнэзул DET сургалт зохион байгууллаа (2018.11.01)



Эрдэнэзул оюутнуудын хамт

10-р сарын 25-нд DET сургагч багш бэлтгэх 2 дахь удаагийн сургалтын төгсөгч Эрдэнэзул DET сургалт хийлээ. Сургалтанд Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвд дадлага хийж буй Нийгмийн ажилтны ангийн 2 оюутан оролцов. Эрдэнэзулын хувьд энэ оны 4 сард сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдсан. Түүний хувьд өнөөг хүртэл хэд хэдэн сургалтанд багийн чиглүүлэгчээр оролцсон бөгөөд энэ удаа DET сургалтын үндсэн сургагч багшаар анх удаа ажиллав. Сургалтын дараа “Их сандарлаа.... Дасгал

ажлуудын агуулгыг бүгдийг нь мэдэж байгаа боловч яг сургалтын үеэр хэд хэдэн зүйл мартсан. Цаашид улам сайжрахын тулд сургалтуудаа үргэлжлүүлэн идэвхтэй хийх болно” гэж байв. Сургалтанд оролцсон оюутнууд “Сургалт явуулж буй хүн ганцаараа ярих бус оролцоонд тулгуурласан сургалт байсан учраас сонирхолтой байсан. Сургуулийнхаа хичээлийн цаг дээр ч гэсэн энэ сургалтыг авч, олон оюутнуудыг хамруулахыг хүсэж байна.” хэмээн ярьж байлаа.

## Зураг авах сургалт (2018.10.26)

Зураг болон бичлэг нь мэдээлэл дамжуулах чухал хэрэгсэл гэдгийг та бүхэн сайн мэдэх байх аа. Жишээлбэл хөгжлийн бэрхшээлийн асуудлыг зургаар илэрхийлэхдээ, бие эрхтний бэрхшээлийг харуулах уу, эсвэл нийгэмд байгаа бэрхшээлийг харуулах уу



Сургалтын үеэр

гэдгээс шалтгаалж хүнд дамжуулах санаа нь өөрчлөгдөх боломжтой. DPUB төсөл Хөгжлийн бэрхшээлийн салбарын нөлөөллийн ажил, төслийн үйл ажиллагааг

олон нийтэд хүргэх ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлж байна. 10-р сарын 23-нд Монгол Япон төвөөс зохион байгуулсан Зураг авах аргачлалын талаарх сургалтанд SINRAI төсөлтэй хамт оролцлоо. Яг нэг зүйлийг яаж авахаас шалтгаалан зураг огт өөр болдгийг харан гайхшруахын зэрэгцээ сайн зураг авах аргад суралцлаа. Гэхдээ сайн зураг авах нь тийм ч амар зүйл биш бөгөөд зураг авах бүртээ арга барилаа сайжруулан, дадал суулгах хэрэгтэйг ойлголоо. Цаашид ч гэсэн та бүхэн цаг алдалгүй мэдээллээ хүргэхийн төлөө хичээн ажиллах болно.

## ESCAP дахь сайхан дурсамжууд



Ахлах зөвлөх Чибэ

ESCAP-д олон сайхан хүмүүс ажилладагийн ихэнх нь Тайланд хүмүүс. Тэд мэргэжилтнүүдийн зааварчилгаагаар бичиг баримт боловсруулах, хурлын бэлтгэл зэргийг хариуцдаг бөгөөд би олон сэтгэл татам хүмүүстэй хамт ажиллаж байсан. Тухайн үед шинэхэн туслах мэргэжилтэн байсан надтай яг л нэг гэр бүлийн хүн шиг харьцдаг байсан Т, үргэлж хөөрхөн охиныхоо талаар ярьдаг О, тэтгэвэрт гарсны дараа мөнгө чухал учраас НҮБ-ээс тэтгэвэрт гарч чадах эсэхдээ санаа зовдог Ү гээд хүн бүр өөр өөрийн онцлогтой байлаа. Тайланд хоол маш амттай бөгөөд төрсөн өдөр, угталт, үдэлтийн арга хэмжээ гээд ямар нэгэн үйл явдал тохиолдоход онцгой өдрийн хоол хамтдаа идэн, хөгжилтэй цаг мөчүүдийг өнгөрөөдөг байв. Ялангуяа надтай дотно найзалдаг байсан G манай даргын нарийн бичиг байсан учраас хамт ажиллахаас гадна өдрийн хоолоо ч цугтаа идэх тохиолдол олон байлаа. Тэрээр герман найз залуутай ба удахгүй хуримаа хийн, хүүхэдтэй болно гэдгээ ч ярьдаг байв. Тэрнээс ч болсон юм уу “G удахгүй нэг гадаад хүнтэй хуримаа хийнэ гэсэн. Тэр нь байнга хамт өдрийн хоол иддэг япон залуу” гэсэн цуу яриа гарсан байв. Тухайн үед бид 2 тэр цуу яриаг сонсоод инээлдэж байсан. НҮБ ч бай хаана ч бай ийм маягийн элдэв цуу яриа гарах нь адилхан юм даа. (Үргэлжлэл бий...)

## DPUB Холбоо барих хаяг

### Хаяг:

Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

### Фэйсбүүк хуудас:

<https://www.facebook.com/jicadpub>

### Цахим хуудас:

<https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

### И-мэйл:

[dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)